



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/16

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Токио-2020” олимпын Пара хөнгөн атлетикийн төрөлд оролцох Монгол улсын шигшээ багийн тамирчин Ховд аймгийн Мөнххайрхан сумын харъяат Э.Гантулгын олимпийн бэлтгэл сургуулилын зардалд 800 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт зарцуулагдах 800 000 төгрөг / Найман зуун мянган /-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4-д тусгагдсан “Спортын аварга” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ